

**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2018.10.30

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	Сумын ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж итгэл, үнэмшил, ил тод байдал бий болно.	Сумын ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан оны эхэнд Засаг даргаар батлуулж хяналтанд аван хэрэгжүүлж байна.	100
2	Батлагдсан төлөвлөгөөг олон нийтэд ил тод мэдээлэх	Төлөвлөгөөг мэдээлсэн байна.	Төлөвлөгөөний талаар мэдээлэлтэй болсон байна.	Сумын ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг мэдээллийн самбарт байршуулж албан хаагчдад танилцуулан зарим заалтыг хяналтандаа авч хэрэгжүүлэх талаар үүрэг өгсөн.	100
3	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг байгуулж хагас бүтэн жилээр тайлагнах	Хэрэгжилтийн түвшинг хагас бүтэн жилээр гаргасан байна.	Хэрэгжилт хугацаандаа үнэн зөв, бодитой гарсан байна.	Сумын ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 10 сарын байдлаар гаргалаа.	70
4	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хяналтандаа авч байгууллагуудад хүргүүлэх, байгууллагуудын авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар батлуулж харъяа төсвийн байгууллагуудад хүргүүлсэн. Хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гаргасан.	70
5	Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь гаргуулан авч холбогдох мэдээ тайланг гаргах	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гаргах	Мэдүүлгийг хугацаанд нь гаргасан байх	Аймгийн ХЭЗХ-т ХАСХОМ мэдүүлэх төрийн албан хаагчдын жагсаалтыг гарган хүргүүлж 7 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь цахимаар гаргуулж баталгааны маягтыг гаргуулж мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж хүргүүлсэн.	100
6	Шинээр албан тушаалд томилогдож байгаа албан	ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж дүгнэлт		2018 онд шинээр 3 албан хаагч томилогдсон. Нийтийн албанд	100

	тушаалтны ХАСУМ-ыг тухай бүр гаргуулж ажиллах	ирсний дараа томилгоог хийх		томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсаны дараа томилж, томилогдсоноос хойш 30 хоногт багтаан ХАСХОМ-ыг гаргуулж ИТХ-ын ЭБАТ-д хугацаанд нь хүргүүлсэн.	
7	ХАС болон ХОМ-ийг мэдүүлэх талаар сургалт зохион байгуулах	Сургалтанд албан тушаалтнууд хамрагдсан байх	ХАСХОМ гаргах талаар мэдээлэлтэй болсон байна.	Шинээр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 3 албан хаагчдад хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах талаар зөвлөгөө мэдээлэл өгч ХОМ гаргадаг төрийн албан хаагчдад сургалт хийж мэдээлэл өгсөн.	100
8	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулах	Ил тод байршуулсан байна.	Худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдал хангагдана.	Худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	100
9	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулах	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулсан байх		2018 онд 1 үнэлгээний хороо байгуулагдаж АЗ сертификаттай иргэдийг үнэлгээний хороонд оруулж ажилласан.	70
10	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан, аудитын дүгнэлтийг мэдээллийн самбарт ил тод байршуулах	Тайлан дүгнэлтийг мэдээллийн самбарт байршуулсан байна.		2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр худалдана авсан бараа ажил үйлчилгээний тайлан болон 2017 оны ОНХС-ийн аудитын дүгнэлийг санхүүгийн мэдээллийн самбарт байршуулсан.	100
11	Тендерийн үнэлгээний хороо болон ажлын хэсэгт ажиллах ажилтнуудаас мэдэгдэл тайлбар гаргуулах, цахимд бүртгэх	НАНБХАСЗАСЗУСТХ-ын 8-р зүйл		2018 онд Үнэлгээний хороо 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Ажлын хэсэгт орсон ажилтнуудаас мэдэгдэл тайлбарыг гаргуулан цахимд мэдээлсэн. Залуучуудын цэцэрлэгт хүрээлэнгийн хашааны тендер зарлагдаж тухайн тендерт 3 компани материал ирүүлснээс шаардлагад нийцэж шалгарсан компани байхгүй.	100

12	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийг цахим хуудсанд тогтмол мэдээлэх	Хуулийн хэрэгжилт хангагдаж, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтын талаарх мэдээлэл ил тод болсон байна.	Байгууллагын үйл ажиллагааг ил тод, мэдээлж хэвшсэн байна.	Шилэн дансны холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв мэдээлж цахим хуудсанд байршуулсан.	100
13	Орон нутгийн газар зохион байгуулалт, газар олголт, иргэдэд өмчлүүлэх болон эзэмшүүлэх боломжтой газрын талаар мэдээлж байх, газар эзэмшлийн талаархи мэдээллийг ил тод болгох	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ил тод байршуулсан байна.	Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байна. Иргэд мэдээллээр хангагдана.	2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг мэдээллийн самбарт байршуулсан. 9-р сард зохион байгуулагдсан багуудын хуралд газрын даамал оролцож гэр бүлийн хэрэгцээний зохиулалтаар шинээр газар өмчилж авах талаар сургалт мэдээллийг хийж нийт 316 иргэн хамрагдсан. 2018 оны 04 сарын 18-нд нээлттэй хаалганы өдөрлөгөөр газар өмчлөлийн талаар гарын авлага, боршурыг тарааж 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгох газрын байршлийг танилцуулсан. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Засаг даргын захирамжаар нийт 63 иргэн гэр бүлийн хэрэгцээний газраа кадастр хийлгүүлэн авсан.	100
14	2018 оны жилийн төсөв, 2017 оны төсвийн гүйцэтгэлийг олон нийтэд ил тод мэдээлэх мэдээллийн самбарт байршуулах	Хуульд зааснаар мэдээлсэн байх	Төсвийн ил тод байдал хангагдана.	2018 оны жилийн төсөв, 2017 оны төсвийн гүйцэтгэлийг ЗДТГ-ын санхүүгийн мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100
15	2017 оны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг мэдээллийн самбарт ил тод байршуулах		Төсвийн зарцуулалт ил тод болно.	2017 оны санхүүгийн дүгнэлтийг ЗДТГ-ын санхүүгийн мэдээллийн самбарт байршуулж dundgobi.gov.mn сайтад аудитын дүгнэлт, санхүүгийн тайланг бүрэн эхээр нь байршуулсан.	100
16	Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй байлгах			Сумын 2018 оны татварын болон татварын бус орлогын мэдээг тухай бүр гаргаж мэдээллийн самбарт байршуулдаг.	100

17	Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны мэдээлэл, журам, хүний нөөцийн бодлого, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд байнга нээлттэй байна.	Нийтэд мэдээлсэн байна.	Иргэд, албан хаагчдад хүний нөөц, сонгон шалгаруулалт ил тод нээлттэй болно.	2018 онд ЭМТ-д 3, ЕБС-д 3, цэцэрлэгт 2, Соёлын төвд 1, ЗДТГ-т 1 орон тоо гарсныг цахим хуудас болон мэдээлийн самбар, зарын самбарт сул орон тоо гарсан тухай мэдээлж дээрх сул орон тоог нөхөж ажилласан. Аймгийн ТАСЗ-д төрийн сангийн мэргэжилтэн, байгаль орчны байцаагчийн сул орон тооны захиалгыг хүргүүлсэн ба зарлагдсан ажлын байрны талаарх мэдээллийг мэдээллийн самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100
18	Хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, сургалт, яриа таниулга, гарын авлага гэх мэт/	Нийтэд мэдээлсэн байх Эрх зүйн хөтөч багийн төлөвлөгөөт сургалт сурталчилгааны хүрээнд сурталчилсан байх	Хуулийн талаарх иргэд албан хаагчдын мэдлэг дээшилнэ.	Хууль тогтоомжуудыг хуулийн мэдээллийн цаг, мэдээллийн самбар, гарын авлага болгон бэлтгэж тарааж	70
19	Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийн самбартай болох	Самбартай болсон байх	Ил тод байдал хангагдана.	Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийн самбартай болсон.	100
20	АТГ болон аймгийн ХЭЗХ-ээс бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, албан хаагчид, байгууллагуудад түгээх	Иргэд, албан хаагчдад түгээсэн байх	Хуулийн талаарх иргэд албан хаагчдын мэдлэг дээшилнэ.	АТГ-аас аймгийн ЗДТГ-т өгсөн зөвлөмж болон ЗГ-ын 2017 оны 326-р тогтоолоор оффшор бүсэд хамаарах гадаад улс орнуудын жагсаалтыг ЗДТГ болон бүх харъяа төрийн байгууллагуудын албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулан авч энэ тухай аймгийн ХЭЗХ-т мэдээлэл хүргүүлсэн.	100
21	Авлигын эсрэг хууль тогтоомж, мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг	Сургалт зохион байгуулсан байх	Албан хаагчид ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ойлголт, мэдлэгтэй болно.	Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж 30 албан хаагч хамрагдсан. ХАСУМ гаргах талаар шинээр томилогдсон 3 албан	70

	дээшлүүлэх сургалт зохион байгуулах			хаагчдад тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч урьдчилсан мэдүүлгийг гаргуулж АТГ-т хүргүүлсэн. ХОМ мэдүүлэхэд анхаарах зүйлсийн талаар ХОМ гаргадаг 7 төрийн албан хаагчдад мэдээлэл хийсэн.	
22	Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар байгууллагын ажилтнуудад зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх	Байгууллагын ажилтнуудад зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлсэн байх	Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүн дээшилнэ.	Авлигын эсрэг хуулийн талаар байгууллагын ажилтнуудад мэдээлэл хийж ажилласан.	70
23	Өргөдөл гомдол, санал хүсэлт авах нөхцлийг бүрдүүлж шийдвэрлэлтийн талаар тогтмол мэдээлж байх	Өргөдөл гомдол хүлээн авах нөхцөл бүрдсэн байна.	-	Сумын хэмжээнд нийт 1020 СӨГ-ыг албан байгууллага, мэргэжилтэн нараас авч шийдвэрлэж мэдээ, тайланг аймагт цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Мөн мэдээллийн самбарт байршуулан ард иргэдэд тогтмол мэдээлж байна. Өргөдөл гомдол, санал хүсэлт авах 89643553 дугаарыг ажилуулж байна.	100
24	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авч, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцох	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх, хариуцлага тооцсон байх	Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой зөрчил гарахгүй.	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/05 тоот тушаалаар ЗДТГ-ын ёс зүйн хороо байгуулагдан ажиллаж байна. Ёс зүйн хороо хуралдаж 2018 оны ажлын төлөвлөгөө, ёс зүйн хороо ажиллаж журмыг боловсруулан батлуулан ажиллаж байна. Мөн 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажилтан, албан хаагчдын ажилд мөрдлөг болгохоор төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ёс зүйн зарчмыг албан хаагч бүрд өгөөд байна. Мөн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулаад байна. Ёс зүйгүй байдал гаргасан 2	100

				албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	
25	ЭБАТ-ыг чадавхжуулж сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан байх	ЭБАТ чадавхжина.	Сургалтанд хамрагдаагүй.	0
26	Хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг сумын хэмжээнд гаргаж, тухайн мэдээллийг нээлттэй болгох	Судалгааг гаргаж ил тод мэдээлсэн байх	Мэдээлэл ил тод байна.	ХАСХОМ мэдүүлдэг төрийн албан хаагчдын хамаарал бүхий этгээдийн судалгааг гаргаж аймгийн ЭБАТ-д хүргүүлэхээс гадна мэдээллийн самбарт байршуулсан.	100
27	Төрийн байгууллагуудад дотоод хяналтын нэгжийг бий болгож үйл ажиллагааг эрчимжүүлэх	Дотоод хяналтын нэгж байгуулна.	Байгууллагын дотоод хяналт сайжирна	ЗДТГ-ын даргын 2017 оны 12 сарын 21-нд А/48 тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгжийг томилсон. Үүний үр дүнд байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор улирал бүр төлөвлөгөөт болон, гэнэтийн шалгалт хийж байгууллагын хурлаар дүнг танилцуулан зөвлөмж өгч ажиллаж байна.	70
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ					87%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР